



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/345

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, МУБИС-ийн дүрмийн 4.6.2 “МУБИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлого”, МУБИС-ийн Эрдэм шинжилгээний хөгжлийн хөтөлбөр, Эрдмийн зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУБИС-ийн санхүүжилттэй судалгааны төсөл, тэтгэлгийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. “МУБИС-ийн санхүүжилттэй судалгааны төсөл, тэтгэлгийг журам”-ыг эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг бүтцийн нэгжүүдийн удирдлагууд, нийт багш, ажилтанд үүрэг болгосугай.

3. Тус журмыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (Б.Хоролдагва)-т үүрэг болгосугай.

4. Журам шинэчлэн батлагдсантай холбоотой МУБИС-ийн захирлын Эрдэм шинжилгээ, инновацын журам батлах тухай 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/318 дугаар тушаал, МУБИС-ийн захирлын МУБИС-ийн санхүүжилттэй судалгааны төслийн журам шинэчлэн батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/274 дүгээр тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

РЕКТОР




Ж.БАТБААТАР

20242616

МУБИС-ийн ректорын 2024 оны 10 дугаар сарын 07-ны
өдрийн А/345 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
САНХҮҮЖИЛТТЭЙ СУДАЛГААНЫ ТӨСӨЛ, ТЭТГЭЛГИЙН ЖУРАМ
(Нэмэлт, өөрчлөлт оруулсан төсөл)



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. МУБИС-ийн багш, ажилтны судалгааны ажлыг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн чанар, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, санхүүжилт олгох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Тус журмын зорилго нь МУБИС-ийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр шинэ мэдлэг, арга, нээлт, дэвшилтэт технологи бүтээх, үйлдвэрлэх, түгээн дэлгэрүүлэх, судалгааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

1.3. Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн хууль, Инновацын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, МУБИС-ийн дүрэм, журамд нийцүүлэн энэхүү журмыг баримтална.

ХОЁР. ТӨСӨЛ, ТЭТГЭЛГИЙН ТӨРӨЛ, ШААРДЛАГА

МУБИС дараах судалгааны төсөл, тэтгэлгийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Суурь судалгааны төсөл
- Инновацын төсөл
- Судалгааны багийн төсөл
- Докторын дараах судалгааны төсөл
- Захиалгат төсөл
- Профессор, дэд профессорын судалгааны тэтгэлэг
- Зочин судлаачийн тэтгэлэг

2.1. Энэхүү журамд хэрэглэгдэж байгаа нэр томъёог дараах утгаар ойлгоно.

2.2.1. “Суурь судалгааны төсөл” гэж шинэ мэдлэг, онол, арга зүй бий болгоход чиглэсэн, үр дүнг олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл эсвэл нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх зорилго бүхий судалгааны ажлыг;

2.2.2. “Инновацын төсөл” гэж МУБИС-ийн нэр дээр мэдүүлсэн эсвэл батлагдсан оюуны өмчийг эргэлтэд оруулах, лицензийн гэрээ хийх, гарааны компани байгуулах, оюуны эрхийн хамгаалалт бүхий инновацыг хэрэглээнд нэвтрүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг санхүүжүүлэх, эргэн төлөгдөх нөхцөлтэй судалгааны ажлыг;

2.2.3. “Судалгааны багийн төсөл” гэж МУБИС-ийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, салбар дундын судалгаа, хамтарсан судалгааг дэмжих зорилгоор үндсэн орон тооны 4-өөс цөөнгүй багш, ажилтан бүхий багийн гүйцэтгэх судалгааны ажлыг;

- 2.2.4. “Докторын дараах судалгааны төсөл” гэж залуу судлаачийн судалгаа, туршилт, инновацын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, судалгааны ажлын дадал төлөвшүүлэх зорилгоор 45 хүртэлх насны багш, ажилтны гүйцэтгэх судалгааны ажлыг;
- 2.2.5. “Захиалгат төсөл” гэж Монгол улс болон МУБИС-ийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, МУБИС-ийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн судалгааны ажлыг;
- 2.2.6. “Профессор, дэд профессорын судалгааны тэтгэлэг” гэж МУБИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор цолтой багш, ажилтны эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх зорилгоор олгох санхүүжилтийг;
- 2.2.7. “Зочин судлаачийн тэтгэлэг” гэж гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас ирж, гэрээ байгуулан 1 сараас дээш хугацаагаар МУБИС-ийн үндсэн багштай хамтран ажиллах судлаачийн судалгааны ажлын санхүүжилтийг;
- 2.3. Төсөл, тэтгэлгийн ангиллыг Суурь судалгааны төсөл (А), Инновацын төсөл (В), Судалгааны багийн төсөл (С), Докторын дараах судалгааны төсөл (D), Захиалгат төсөл (E), Профессор, дэд профессорын судалгааны тэтгэлэг (F), Зочин судлаачийн тэтгэлэг (G) хэмээн латин үсгээр тэмдэглэнэ.
- 2.4. Төсөл, тэтгэлгийг дараах стандартын дагуу дугаарлана. Сургуулийн нэрийн товчлол (англи том үсгээр), төсөл хэрэгжиж эхэлсэн он, төслийн ангилал (латин том үсгээр), дугаар (тоогоор) гэсэн дарааллаар, жишээлбэл: MNUE2024A001 гэж тэмдэглэнэ.
- 2.5. Төсөл, тэтгэлэг мэдүүлэгч нь докторын зэрэгтэй МУБИС-ийн үндсэн орон тооны багш, ажилтан байна.
- 2.6. Тэтгэлэг, төсөл хэрэгжүүлэх хугацаа дуусаагүй болон үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэж өгөөгүй удирдагч, багийн гишүүд дараагийн судалгааны санхүүжилтийн хүсэлт мэдүүлэх эрхгүй.
- 2.7. Давтан төсөл мэдүүлж буй тохиолдолд хүлээгдэж буй үр дүн нь өмнө хэрэгжүүлсэн төслийнхөөс заавал ахисан байна.
- 2.8. Төсөл хэрэгжүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон үндсэн хөрөнгө, оюуны бүтээл нь МУБИС-ийн өмч байна.

ГУРАВ. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСӨЛ

- 3.1. Суурь судалгааны төсөлд дараах шаардлага тавигдана.Үүнд:
- 3.1.1. МУБИС-ийн болон салбар, бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх;
- 3.1.2. Олон улсын мэдээллийн сан (Web of Science эсвэл Scopus)-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл эсвэл нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх;
- 3.2. Судалгааны ажлын санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
- 3.2.1. Өгүүлэл, нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх;
- 3.2.2. Судалгаа шинжилгээ, сорилт туршилтад шаардагдах материал худалдан авах;
- 3.2.3. Өгөгдөл цуглуулах болон бичиг хэргийн зардал;
- 3.2.4. Багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл, өгүүлэл, программ худалдан авах;
- 3.2.5. Лабораторийн болон хээрийн судалгаанд зарцуулах;
- 3.2.6. Олон улсын хуралд оролцох, судалгааны семинар зохион байгуулах;
- 3.3. Төслийг хэрэгжүүлэх хугацаа 1 жил байна.

ДӨРӨВ. ИННОВАЦЫН ТӨСӨЛ

4.1. Инновацийн төсөлд дараах шаардлага тавигдана. Үүнд:

4.1.1. Төслийн шинэлэг тал болон оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг нотолсон байх;

4.1.2. Техник, эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол, үр ашгийн тооцоог хийсэн байх;

4.1.3. Зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээтэй харьцуулсан судалгаа хийсэн байх;

4.1.4. Бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийх талаарх мэдээллийг боловсруулсан байх;

4.2. Инновацийн төслийн санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:

4.2.1. Патент, лиценз мэдүүлэхтэй холбоотой зардал;

4.2.2. Шаардлагатай тоног, төхөөрөмж, программ хангамж худалдан авах;

4.3. Инновацийн төсөл нь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөгдөх мөнгөн дүнг гэрээгээр зохицуулна.

4.4. Төслийг хэрэгжүүлэх хугацаа 1 жил байна.

ТАВ. СУДАЛГААНЫ БАГИЙН ТӨСӨЛ

5.1. Судалгааны багийн төсөлд дараах шаардлага тавигдана. Үүнд:

5.1.1. МУБИС-ийн болон салбар, бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх;

5.1.2. Олон улсын мэдээллийн сан (Web of Science эсвэл Scopus)-д бүртгэлтэй сэтгүүлд 3-аас цөөнгүй өгүүлэл хэвлүүлэх;

5.1.3. Судалгааны багийн бүрэлдэхүүнд ахисан түвшний суралцагчид хамрагдсан байх;

5.2. Судалгааны ажлын санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:

5.2.1. Сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;

5.2.2. Судалгаа шинжилгээ, сорилт туршилтад шаардагдах материал худалдан авах;

5.2.3. Өгөгдөл цуглуулах болон бичиг хэргийн зардал;

5.2.4. Багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл, өгүүлэл, программ худалдан авах;

5.2.5. Лабораторийн болон хээрийн судалгаанд зарцуулах;

5.2.6. Олон улсын хуралд оролцох, судалгааны семинар зохион байгуулах;

5.2.7. Гадаад судлаачийн Монголд байх хугацааны үйлчилгээний зардал;

5.3. Төслийг хэрэгжүүлэх хугацаа 3 жилээс хэтрэхгүй ба судалгааны үр дүнд үндэслэн гэрээний сунгалтыг жил бүр хийнэ.

ЗУРГАА. ДОКТОРЫН ДАРААХ СУДАЛГААНЫ ТӨСӨЛ


6.1. МУБИС-ийн залуу багш, ажилтан докторын (Ph.D) зэрэг хамгаалснаас хойш 5 жилийн доторх хугацаанд 1 удаа хамрагдах боломжтой.

6.2. Төслийн үр дүнд олон улсын мэдээллийн сан (Web of Science эсвэл Scopus)-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл эсвэл нэг сэдэвт бүтээл хэвлүүлнэ.

6.3. Докторын дараах судалгааны тэтгэлгийн санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:

6.3.1. Өгүүлэл, нэг сэдэвт бүтээл хэвлүүлэх;

- 6.3.2. Судалгаа шинжилгээ, сорилт туршилтад шаардагдах материал, эм, урвалж бодис, тоног төхөөрөмж, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах;
- 6.3.3. Монгол улсын патент, ашигтай загвар мэдүүлэх;
- 6.3.4. Эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцох;
- 6.3.5. Лабораторийн болон хээрийн судалгаанд зарцуулах;
- 6.4. Төслийг хэрэгжүүлэх хугацаа 2 жилээс хэтрэхгүй ба эхний жилийн үр дүнд үндэслэн гэрээний сунгалтыг хийнэ.



ДОЛОО. МУБИС-ИЙН ЗАХИАЛГАТ ТӨСӨЛ

- 7.1. Монгол улсын хөгжлийн бодлого, МУБИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор МУБИС-ийн ректорын зөвлөлөөс захиалгат төслийг зарлана.
- 7.2. Судалгааны ажлын санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
- 7.2.1 Судалгааны материал, мэргэжлийн ном, сэтгүүл, өгүүлэл, программ хангамж худалдан авах;
- 7.2.2. Өгөгдөл цуглуулах, хэвлэлийн эх бэлтгэл, бичиг хэргийн зардал;
- 7.2.3. Эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- 7.2.4. Судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх;
- 7.3. Төслийг хэрэгжүүлэх хугацаа 1 жил байна.
- 7.4. Захиалгат төслийн үр дүнг ректорын зөвлөлд танилцуулна.

НАЙМ. ПРОФЕССОР, ДЭД ПРОФЕССОРЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГ

- 8.1. МУБИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор цолтой багш, ажилтан хамрагдана.
- 8.2. Судалгааны ажлын санхүүжилтийг дараах зардалд зарцуулна. Үүнд:
- 8.2.1. Олон улсын мэдээллийн сан (Web of Science эсвэл Scopus)-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;
- 8.2.2. Нэг сэдэвт эрдэм шинжилгээний бүтээл, мэргэжлийн сурах бичиг хэвлүүлэх;
- 8.2.3. Лабораторийн болон хээрийн судалгаа хийх;
- 8.2.4. Итгэмжлэгдсэн лабораторид судалгааны дээж шинжлүүлэх, сорьц боловсруулах;
- 8.2.5. Олон улсын судалгааны төв, лабораторид ажиллах, туршилт явуулах;
- 8.2.6. Зочин судлаач урих, хамтарсан судалгаа хийх;
- 8.2.7. Патент, лиценз авах;
- 8.2.8. Гадаад томилолт (тухайн судалгааны сэдэвтэй шууд холбоотой байх);
- 8.2.9. Олон улсын хуралд оролцох;
- 8.2.10. Судалгааны семинар удирдаж явуулах;
- 8.2.11. Мэргэжлийн сурах бичиг орчуулах
- 8.3. Тэтгэлгийн хүлээгдэж буй үр дүн нь 1 жил байна.

ЕС. ЗОЧИН СУДЛААЧИЙН ТЭТГЭЛЭГ

- 9.1. Зочин судлаачийн тэтгэлэгт гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилладаг судлаач хамрагдана.
- 9.2. Зочин судлаач нь МУБИС-ийн үндсэн орон тооны багштай хамтарсан судалгаа хийнэ.

- 9.2. Зочин судлаачийн тэтгэлэгт дараах шаардлага тавигдана. Үүнд:
- 9.2.1. Зочин судлаач болон түүнтэй хамтарсан судалгаа хийх багш, ажилтан нь олон улсад судалгааны ажлаа хэвлүүлсэн туршлагатай байх;
- 9.2.2. Судалгааны ажлын хэрэгжих боломж, үр дүнгийн баталгааг харуулсан ажлын төлөвлөгөөтэй байх;
- 9.2.3. МУБИС-ийн багш, ажилтантай хамтран олон улсын мэдээллийн сан (Web of Science эсвэл Scopus)-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх эсвэл төсөл хэрэгжүүлэх;
- 9.2.4. Судалгааныхаа чиглэлээр МУБИС-ийн багш, суралцагчдад сургалт, семинар явуулах, зөвлөгөө өгөх;
- 9.3. Зочин судлаачийн тэтгэлгийн санхүүжилтийг түүнтэй хамтран ажиллах МУБИС-ийн багш, ажилтантай хийх гэрээгээр зохицуулж, дараах зардалд зарцуулна. Үүнд:
- 9.3.1. Судалгааны зардал;
- 9.3.2. Сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх зардал;
- 9.3.3. Зочин судлаачийн ажлын хөлс (судлаачийн ажлын туршлага бусад хүчин зүйлсийг харгалзан, МУБИС-ийн багшийн ажиллах журамд үндэслэн харилцан зөвшилцөх замаар тогтооно);
- 9.4. Зочин судлаач нь эрүүл мэндийн даатгалыг өөрөө хариуцна.
- 9.5. Зочин судлаачийг хичээлийн жилийн хугацаанд ирүүлэхийг чухалчилна.
- 9.6. Зочин судлаачийн ажлын байр, техник хэрэгслийг урьж ажиллуулж буй салбар, бүрэлдэхүүн сургууль, нэгж хариуцна.
- 9.7. Зочин судлаачийн ажлын үр дүнг түүнтэй хамтран ажилласан багш, ажилтан ректорын зөвлөлд танилцуулна.
- 9.8. Тэтгэлгийн саналыг англи, монгол хэл дээр бичнэ.

АРАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- 10.1. Сонгон шалгаруулалт нь ил тод, нээлттэй, шударга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид тэгш боломж олгосон байна.
- 10.2. Төсөл, тэтгэлгийн саналыг тэнхимийн хурал, салбар, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 11 дүгээр сарын 01-ний дотор МУБИС-ийн Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 10.3. Төсөл, тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг ректорын тушаалаар байгуулсан ажлын хэсэг зохион байгуулна. Захиалгат төсөл, зочин судлаачийн тэтгэлгийн саналыг ректорын зөвлөлөөр хэлэлцэж шалгаруулна.
- 10.4. Сонгон шалгаруулалтыг нэг сарын хугацаанд хийн, шалгарсан төсөл, тэтгэлгийн гэрээг 12 дугаар сарын 01-ээс 20-ны өдрийн дотор байгуулж, гэрээний хүчинтэй хугацааг санхүүгийн жилээр тооцно.
- 10.5. Ажлын хэсгийн гишүүн өөрийн оролцоо бүхий төсөл, тэтгэлэгт үнэлгээ өгөх эрхгүй болно.
- 10.6. Суурь судалгаа, докторын дараах судалгаа болон судалгааны багийн төслийн санхүүжилтийг судалгааны хүрээнд тодорхой ажил хийгдсэн, анхдагч үр дүн гарсан судалгааны ажлыг дэмжих чиглэлд зарцуулахыг илүүд үзнэ.
- 10.7. Судалгааны төслийн удирдагч, багийн гишүүнээр тухайн жилд нэг төсөлд зөвхөн нэг удаа оролцоно.

АРВАН НЭГ. ГЭРЭЭ, САНХҮҮЖИЛТ

11.1. Шалгарсан төсөл, тэтгэлгийн гэрээг гурван хувь үйлдэн МУБИС-ийн ректорын эрх олгосноор Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор, салбар, бүрэлдэхүүн сургуулийн захирал, төслийн удирдагч нар гарын үсэг зурж, баталгаажуулна.

11.2. Төсөл, тэтгэлгийг МУБИС бие даан санхүүжүүлэх ба тухайн жилийн санхүүжилтийн хэмжээг төрөл тус бүрээр ректорын зөвлөл тогтооно.

11.3. Төслийн нийт санхүүжилтийн 25 хүртэл хувийг төслийн багийн гишүүдийн ажлын хөлсөнд зарцуулж болно. Тэтгэлгийн санхүүжилтийг ажлын хөлсөнд зарцуулахгүй

11.4. Гэрээ баталгаажсанаар санхүүжилтийн 70% олгогдоно. Тухайн оны 5 сард багтаан судалгааны ажлын явцын тайланг салбар, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж хугацаандаа хэрэгжиж байгаа төслийн үлдсэн санхүүжилтийг олгох хүсэлтийг Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ. Гэрээний биелэлт, гүйцэтгэлийг хянан Санхүүгийн асуудал хариуцсан нэгжид хүсэлтийг хүргүүлснээр санхүүжилтийг олгоно.

11.5. Судалгааны санхүүжилтийг бүрэлдэхүүн, салбар сургууль болон захиргааны данс руу шилжүүлэх бөгөөд төлбөр тооцоо, хяналт үнэлгээг МУБИС-ийн Санхүүгийн журмын харгалзах заалтуудыг баримтлан хийж, хэрэгжилтийг нь ректор болон салбар, бүрэлдэхүүн сургуулийн захирал хянан.

11.6. Санхүүгийн асуудал хариуцсан нэгж санхүүжилтийг зориулалтын дагуу ашиглаж буй байдал, худалдан авалт бүрд аудит хийх, санхүүгийн баримт бичгийн бүрдүүлэлт, тайлагнал, төслийн хүрээнд өр төлбөр үүссэн эсэх, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийн хувьд эргэн төлөлтийн байдал зэрэгт хяналт тавьж ажиллана.

11.7. Төслийн багийн гишүүн зөвшөөрсөн тохиолдолд төслийн удирдагч төслийн гэрээг шилжүүлж болно.

АРВАН ХОЁР. ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

12.1. Төсөл, тэтгэлгийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах, тооцох, аудит хийх, санхүүгийн тооцоотой холбоотой асуудлыг Эрдэм шинжилгээний, Санхүүгийн, Чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгжүүд хамтран хариуцна.

12.2. Эцсийн тайланг тэнхим, салбар, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж үр дүнг актаар 12 дугаар сарын 15-ны дотор Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд эрдмийн зөвлөлийн протокол, үр дүнгийн баталгаажуулалт, тайланг хянан магадалж төслийг хаана.

12.3. Санхүүгийн зарцуулалтаа салбар, бүрэлдэхүүн сургуулийн болон захиргааны нягтлан бодогчид тайлагнана.

АРВАН ГУРАВ. ҮР ДҮНГ ТҮГЭЭХ

13.1. Судалгааны тайлан, үр дүн, бүтээгдэхүүнийг Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгжид хүлээлгэн өгч, мэдээллийг МУБИС-ийн эрдэм шинжилгээний мэдээллийн нэгдсэн санд оруулна.

13.2. Үр дүнг хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр түгээх, сурталчлахдаа МУБИС-ийн судалгааны санхүүжилтээр гүйцэтгэсэн болохыг заавал дурдана.

13.3. Үр дүнг өргөжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж судлаачийн мөшгөх судалгаа хөтөлнө.

АРВАН ДӨРӨВ. ТӨСӨЛ, ТЭТГЭЛЭГТ ХАМРАГДАГЧИЙН ХАРИУЦЛАГА

- 14.1. Судалгааны төсөл, тэтгэлэг авч гэрээ байгуулсан багш, ажилтан гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй, энэхүү журам болон гэрээнд заасан шаардлага бүхий үр дүнг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд судалгааны ажлын санхүүжилтийг буцаан төлнө.
- 14.2. Удирдагч үр дүнд тооцуулах бүтээлийн зохиогч байх ба МУБИС-ийн судалгааны санхүүжилтийн мэдээлэл, төсөл, тэтгэлгийн дугаар дурдагдаагүй бүтээлийг үр дүнд тооцож хүлээн авахгүй.
- 14.3. Судалгааны санхүүжилт авсан профессор багш, ажилтан судлаачийн ёс зүйг баримтална. Судлаачийн ёс зүйтэй холбоотой үүсэж болзошгүй аливаа асуудлыг төсөл, тэтгэлэгт хамрагдагч өөрөө хариуцна.
- 14.4. Хүндэтгэн үзэх шалтгаантайгаар судалгааны ажлын үр дүнг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй, тайлагнаагүй тохиолдолд салбар, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөл судлаачийн хүсэлтийг үндэслэн судалгааны ажлын хэрэгжилтийг хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл гэрээг 1 жилээр сунгах саналыг Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгжид ирүүлж шийдвэрлүүлнэ.
- 14.5. Төслийн үр дүнгээр бий болсон бүтээлийн оюуны өмчийн асуудлыг “МУБИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлого”, “Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам”, “Патентын тухай”, “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар зохицуулна.